

Угтах үйлчилгээний сургагч багш Сүгаяатай хамт (Архангай аймгийн ЭМНДХ)



ЖАЙКА НИЙГМИЙН
 ДААТГАЛЫН ҮЙЛ
 АЖИЛЛАГААНЫ
 ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ
 ТӨСӨЛ

МЭДЭЭЛЭЛ №6



2016 оны 12 сар

★ТӨСЛИЙН ВЕБСАЙТ НЭЭГДЛЭЭ★ [HTTP://WWW.JICA.GO.JP/PROJECT/MONGOLIA/014/INDEX.HTML](http://www.jica.go.jp/project/mongolia/014/index.html)

ҮНДСЭН АГУУЛГА

Япон улсаас богино хугацааны
 мэргэжилтэнг урьж, угтах
 үйлчилгээний талаар сургалт
 зохион байгууллаа.



Сургалтын явц

11 сарын 28-с 12 сарын 9-ны хооронд, Япон улсаас угтах үйлчилгээний сургагч багш Сүгаяа уригдан ирж, ЭМНДЕГ болон зарим аймаг, дүүргүүдийн ЭМНДХ дээр сургалт зохион байгууллаа.



Үйлчлүүлэгчтэй харьцах практик дасгал

Уг сургалтаар үйлчлүүлэгчтэй харьцах үндсэн мэдлэг болоод мэдээлэл өгөх, гомдол шийдвэрлэх аргууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх үйлчилгээний соёлыг практик дасгал дээр тайлбарлан заалаа. Сургалтанд оролцогчид үйлчлүүлэгчийн нүдээр өөрийгөө харж бодитоор дасгал хийсэн нь ихээхэн үр дүнтэй байлаа. Сүгаяа багш:



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх дасгал хичээл

Үйлчлүүлэгчийн сэтгэлд нийцсэн үйлчилгээг үзүүлэхийн тулд сайн муу аль аль талаа баг хамт олноороо сайтар ярилцаж мэдээлэл солилцох, цаашлаад нийт ажилчдын ур чадварыг дээшлүүлэх нь чухал гэдгийг онцолж байлаа. Багаар ажиллахын чухлыг оролцогчид мөн олж харж чадлаа.



Сүгаяа багшийн хамт

Сургалтанд нийт 170 гаруй албан хаагчид оролцсон бөгөөд сургалтаар сурч мэдсэн зүйлээ бодитоор үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

Таканаши мэргэжилтний сэтгэгдэл (практик үйл ажиллагааг сайжруулах баг)

Энэ удаагийн сургалтыг зөвхөн ширээний араас сонсох биш багт хуваан, төрөл бүрийн практик дасгал хийлгэсэн нь ихээхэн үр дүнтэй байлаа. Сургалтанд идэвхтэй оролцсон нийт ажилтнууддаа талархал илэрхийлье.



Цуврал нийтлэл “Монгол орны нийгмийн хамгаалал”

Монгол улсын нийгмийн даатгалын өнөөгийн байдал, төслөөр дамжуулж ойлгож мэдсэн зүйлээ тухай бүрт нь та бүхэнд танилцуулж байх болно. Энэ удаа “Залуу үеийнхний нөлөөлөл” сэдвээр өгүүлье. (Зураг: Нарлаг УБ Ротари клубын гишүүд)



МУИС-н Хууль зүйн сургуулийн оюутнуудад яриа хийлээ.

МУИС-н оюутнуудад нийгмийн даатгал, тэтгэврийн ач холбогдлын талаар ярьж, харилцан санал бодлоо солилцлоо. (Зураг: Хууль зүйн сургуулийн оюутнуудын хамт)

Зургаа дахь нийтлэл: 「Залуу үеийнхэний нөлөөлөл」

Сайн байцгаана уу.

Энэ удаагийн нийтлэлдээ улс орноо авч явах залуу үеийнхэн ямар чухал оролцоотой байдгийг өгүүлэхээр шийдлээ.

Та бүхэн мэдэж байгаа, Япон улс өндөр настан олонтой буюу 2014 оны байдлаар нийт хүн амын 25.9 хувийг 65-с дээш насныхан эзэлж байна. Дөрвөн хүн тутмын нэг гэсэн үг юм.

Гэхдээ 1950 оны үед байдал өөр байлаа. Өндөр настнууд нийт хүн амын 4.8 хувийг эзэлж байсан бол, 20 хүртэлх насны залуус 45.7 хувийг, 30 хүртэлх насныхан 62.4 хувийг тус тус эзэлж байв. Өөрөөр хэлвэл таван хүн тутмын гурав нь залуучууд байсан юм.

65 жилийн өмнө Япон улсад залуучууд харьцангуй олон байсан учир аж үйлдвэрийн салбарт ажиллах боловсон хүчин хангалттай их байв. Мөн залуус гэр бүлтэй болж, хот суурин газарт төвлөрөн амьдрах болсноор өнгөт зурагт, автомашин, сэрүүцүүлэгч гэх мэт цахилгаан барааны худалдан авалт ихэсж, улмаар эдийн засгийн өсөлтөд эерэгээр нөлөөлсөн юм. Үүнтэй зэрэгцэн нийгмийн хамгааллын тогтолцоо ч бүрэлдэн бий болсон билээ.

Монгол улсын хүн амын бүтцийг харвал 2015 оны байдлаар 20 хүртэлх насныхан нийт хүн амын 37.4 хувийг, 30 хүртэлх насныхан 56.5 хувийг эзэлж байна. Эдгээр залуучууд цаашид монгол орны хөгжилд гол үүрэг

гүйцэтгэх нь дамжиггүй юм. Залуучууд их байна гэдэг маань Монгол улс маш том капиталтай байна гэсэн үг. Энэ үнэт зүйлээр дамжуулж нийгмийн хамгааллыг улам хүртээмжтэй, үр дүнтэй болгох нь манай төслийн томоохон зорилго билээ.

Төслийн ахлах зөвлөх Ямашита Мамору

МУИС-н Хууль зүйн сургуулийн оюутнуудад яриа хийлээ.

11 сарын 21-ны өдөр, Нагоягийн их сургуулийн Японы эрх зүйн боловсрол, судалгааны төвтэй хамтран МУИС-ийн Хууль



зүйн сургуулийн оюутнуудад нийгмийн даатгалын талаар яриа хийлээ. Хувийн хадгаламж ба тэтгэврийн даатгалын ялгаа, нийгмийн даатгалын үйл ажиллагааг улс



хариуцан хэрэгжүүлэх ач холбогдол, Япон улсын эрүүл мэндийн даатгалын тогтолцооны талаар нэг цаг орчим ярилцлаа. Оюутнууд тэтгэврийн даатгалын шимтгэл, тэтгэвэр олголтын хэмжээн өнгөрсөн ба одоо

үйеийнхэн ягаад тэгш бус байгаа талаар, мөн шимтгэл төлөх хугацаа тухайн хүнээс шалтгааж ягаад өөрчлөгддөг талаар асуулт асууж байлаа. Монгол улсын ирээдүй болсон

залуу үеийнхэнтэй уулзаж ярилцах сайхан завшааныг олгосон Нагоягийн их сургуулийн Японы эрх зүйн боловсрол, судалгааны төвийн хамт олонд баярласан талархсанаа илэрхийлэе.

Улаанбаатарын Их Сургууль дээр нийгмийн даатгалын талаар яриа хийлээ.

12 сарын 7-ны өдөр Улаанбаатарын Их Сургуулийн багш оюутнуудад нийгмийн даатгал, гэр



дундаа аливаа эрсдэлд ороход та ганцаараа биш бүх нийтээрээ нэгдмэл байдлаар

бие биедээ харилцан туслалцан туслах нь ямар чухал болох талаар голчлон ярилцлаа. Нийт оролцогчид болон бидэнд яриа хийх боломж олгосон ЖАЙКА-н сайн дурын гишүүн Сава таньд баярласан талархсанаа илэрхийлэе. (Зураг: Тус сургуулийн багш ажилчидтай хамт)



Ямашита ахлах зөвлөхийн ажлаас . .

Орос Монголын нийгэм эдийн засгийн бодлогын талаарх олон улсын бага хуралд Япон талаас ганцаараа оролцож нийгмийн хамгааллын тогтолцооны талаар, тодруулбал хүн ам зүйн хувьд залуучууд их байгаа өнөө үед тогтолцоогоо бүрэн тогтворжуулж, шимтгэлээс орж ирэх хуримтлалыг дэд бүтцийн хөрөнгө оруулалтанд ашиглаж, дундаж давхаргынханы тоог олшруулах шаардлагатай талаар лекц уншиж, оролцогчидтой санал бодлоо солилцлоо. Тус хуралд оролцох боломж олгосон МУИС-ын Бизнесийн сургуулийн доктор Г.Бурмаа таньд талархал илэрхийлэе.

Төслийн албан ёсны фэйсбүүк хуудасд тавтай морилно уу.

Фэйсбүүк хуудсаар дамжуулж төслийн үйл ажиллагааны талаар цаг тухайд нь мэдээлэл авахаас гадна төслийн ахлах зөвлөхийн нийгмийн даатгалын холбогдолтой нийтлэлүүдийг унших боломжтой.

Жайка Нийгмийн Даатгалын төсөлさんが写真4件を追加しました — 場所: Архангай Аймаг
 作成者: Erika Kikuchi | 昨日 14:18



<接遇向上手法セミナー@アルハンガイ県>
 Сугаа мэргэжилтэн маань Архангай аймгийн ЭМНДХ дээр угтах үйлчилгээний чанарыг сайжруулах аргачлалын талаар сургалт зохион байгууллаа. Оролцогчид үйлчилгээний соёлын тухай их зүйлийг сурч мэдсэн үр дүнтэй сургалт болж өнгөрлөө. 接遇業務短期専門家による、接遇向上手法についてのセミナーがアルハンガイ県医療・社会保険事務所にて行われました。たくさんの方に参加いただき、非常に充実したセミナーとなっています。



QR код ↓



ТӨСЛИЙН ХАЯГ • ХОЛБОО БАРИХ УТАС

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг Хуульчдын гудамж 13/1, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар 6 давхар 602 тоот

Утас (Факс) : (+976)-11-325125

Өмнөх мэдээллийг доорх линкээр орж авна үү
<http://www.jica.go.jp/project/mongolia/014/newsletter/index.html>

Албан ёсны фэйсбүүк хаяг: Жайка Нийгмийн Даатгалын төсөл